

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/148/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН МОНГОЛ ТУУРГАТАН ТЕАТРЫН 2025 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Б.Нямсүрэн

Утас: 70272248 Цахим хаяг: [nyamsurenb@audit.gov.mn](mailto:nyamsurenb@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт

### 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



#### ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582. Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

д/б/б.а.а. 24 № 01/106  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Монгол туургатан театрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Монгол туургатан театрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Монгол туургатан театрын даргын 2025 оны 1 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дугаар тушаалаар бүтэц орон тоог 59 орон тоотойгоор баталсан байна. Тайлант онд захиргаа удирдлага 8, үйлдвэр зохион байгуулалтын анги 16, дуу анги 9, бүжиг анги 9, драм анги 7, хөгжим анги 10, нийт 59 орон тоотой ажилласан байна.

#### Аудитын гол асуудал

Тус байгууллага нь "Дэлхийн театр"-ын баярын өдрийг тохиолдуулж Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын уран зохиолч Б.Лхагвасүрэнгийн зохиол "Би хаан болохгүй" хүүхдийн жүжгийг 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр 450 хүүхэд багачуудад үнэ төлбөргүй толилуулсан байна.

#### Бусад асуудлын хэсэг

Монгол туургатан театр нь гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт, 26 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, гүйцэтгэлээр 92,0 хувийн биелэлттэй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

4126020150

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	709,989,751.72	594,597,340.53
33	АВЛАГА	6,773,693.62	7,499,926.43
335	Бусад авлага	6,773,693.62	7,499,926.43
3351	Байгууллагаас авах авлага	6,600,116.97	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	173,576.65	7,499,926.43
35	БАРАА МАТЕРИАЛ	703,216,058.10	587,097,414.10
351	Түүхий эд материал	614,154,514.00	541,505,704.00
35110	Тусгай зориулалттай материал	614,154,514.00	541,505,704.00
354	Хангамжийн материал	89,061,544.10	45,591,710.10
35410	Бичиг хэргийн материал	4,180,430.00	5,497,030.00
35420	Аж ахуйн материал	74,849,114.10	30,062,680.10
35470	Бусад хангамжийн материал	10,032,000.00	10,032,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,997,875,754.23	9,004,860,255.74
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,997,875,754.23	9,004,860,255.74
392	Биет хөрөнгө	8,757,542,754.23	8,764,443,255.74
39201	Барилга, байгууламж, орон сууц	9,514,556,000.00	9,514,556,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(964,000,339.68)	(1,122,346,272.96)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	84,920,000.00	59,444,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(84,920,000.00)	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	183,327,904.34	201,424,683.04
39206	Хуримтлагдсан элэгдэл	(56,265,950.55)	(72,879,541.60)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	180,931,381.50	136,000,548.05
39208	Хуримтлагдсан элэгдэл	(165,006,241.42)	(9,862,119.86)
39214	Бусад үндсэн хөрөнгө	95,884,285.70	90,105,958.99
39215	Хуримтлагдсан элэгдэл	(31,884,285.66)	(31,999,999.92)
393	Биет бус хөрөнгө	240,333,000.00	240,417,000.00
39301	Програм хангамж	2,280,000.00	2,100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,272,000.00)	(1,008,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	239,325,000.00	239,325,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>9,707,865,505.95</b>	<b>9,599,457,596.27</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	13,947,032.60	41,271,882.24
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	13,947,032.60	41,271,882.24
413	Өглөг	13,947,032.60	41,271,882.24
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	12,289,002.60	645,147.79
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	34,814,834.45
4136	Бусад өглөг	1,658,030.00	5,811,900.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,658,030.00	5,811,900.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,693,918,473.35	9,558,185,714.03
51	Засгийн газрын хувь оролцоо	9,693,918,473.35	9,558,185,714.03
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	816,099,394.39	816,099,394.39
51101	Өмч: - төрийн	499,974,394.39	499,974,394.39
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	316,125,000.00	316,125,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	8,874,999,798.15	8,741,073,903.58
51210	Өмнөх үеийн үр дүн	8,874,999,798.15	8,876,806,662.90
51220	Тайлант үеийн үр дүн	-	(135,732,759.32)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,819,280.81	1,012,416.06
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>9,707,865,505.95</b>	<b>9,599,457,596.27</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,711,815,256.41</b>	<b>2,917,497,021.78</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	104,901,256.00	236,499,990.08
120	Нийтлэг татварын бус орлого	104,901,256.00	236,499,990.08
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	34,171,500.00	35,918,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	34,171,500.00	35,918,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,606,914,000.41	2,680,997,031.70
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	784,984,600.00	765,309,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	784,984,600.00	765,309,200.00
1330	Төсвийн захирагчдаас	1,821,929,400.41	1,915,687,831.70
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,821,929,400.41	1,915,687,831.70
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,876,971,829.03</b>	<b>3,053,229,781.10</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,876,971,829.03	3,053,229,781.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,741,109,799.43	3,030,688,838.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,411,420,397.10	1,627,745,998.03
210101	Үндсэн цалин	924,172,706.58	982,033,494.46
210102	Нэмэгдэл	323,628,192.70	466,650,075.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	60,115,933.22	66,343,435.54
210104	Урамшуулал	103,503,564.60	112,718,992.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	175,668,545.65	214,423,807.24
210201	Тэтгэврийн даатгал	121,355,300.00	148,828,707.24
210202	Тэтгэмжийн даатгал	14,277,100.00	16,398,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,138,600.00	8,199,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,343,346.18	8,199,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	26,554,199.47	32,797,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	726,154,619.01	710,124,034.44
210301	Гэрэл, цахилгаан	15,829,841.38	25,123,608.44
210302	Түлш, халаалт	698,571,596.63	675,417,600.00
210303	Цэвэр, бохир ус	11,753,181.00	9,582,826.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,763,400.00	6,231,100.00
210401	Бичиг хэрэг	7,761,500.00	3,833,600.00
210402	Тээвэр, шатахуун	5,600,000.00	1,460,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,681,900.00	937,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46,897,800.00	117,716,230.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	550,000.00	8,167,500.00
210604	Урсгал засвар	46,347,800.00	109,548,730.00
2107	Томилолт, зочны зардал	2,700,000.00	1,110,000.00
210702	Дотоод албан томилолт	2,700,000.00	1,110,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	151,607,481.20	138,812,280.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	151,427,481.20	136,997,880.04
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,814,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	180,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	210,897,556.47	214,525,388.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,313,600.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	209,583,956.47	214,525,388.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	135,862,029.60	22,540,942.78
2132	Бусад урсгал шилжүүлэг	85,327,722.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,120,112.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	78,601,910.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,605,700.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	50,534,307.60	22,540,942.78
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(165,156,572.62)	(135,732,759.32)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(165,156,572.62)</b>	<b>(135,732,759.32)</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,641,085,500.41</b>	<b>2,716,915,031.70</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	34,171,500.00	35,918,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	34,171,500.00	35,918,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	34,171,500.00	35,918,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	34,171,500.00	35,918,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,606,914,000.41	2,680,997,031.70
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	784,984,600.00	765,309,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	784,984,600.00	765,309,200.00
1330	Төсвийн захирагчдаас	1,821,929,400.41	1,915,687,831.70
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,821,929,400.41	1,915,687,831.70
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,659,176,028.92</b>	<b>2,716,915,031.70</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,659,176,028.92	2,716,915,031.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,519,720,211.32	2,686,974,088.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,411,420,397.10	1,626,738,708.60
210101	Үндсэн цалин	924,172,706.58	981,026,205.02
210102	Нэмэгдэл	323,628,192.70	466,650,075.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	60,115,933.22	66,343,435.55
210104	Урамшуулал	103,503,564.60	112,718,992.96
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	175,668,546.18	205,753,450.33
210201	Тэтгэврийн даатгал	121,355,300.00	140,158,350.33
210202	Тэтгэмжийн даатгал	14,277,100.00	16,398,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,138,600.00	8,199,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,343,346.18	8,199,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	26,554,200.00	32,797,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	703,802,968.04	675,309,199.99
210301	Гэрэл, цахилгаан	15,829,841.38	25,123,608.44
210302	Түлш, халаалт	676,219,945.66	640,602,765.55
210303	Цэвэр, бохир ус	11,753,181.00	9,582,826.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,772,800.00	14,518,000.00
210401	Бичиг хэрэг	7,582,500.00	4,714,200.00
210402	Тээвэр, шатахуун	6,322,000.00	1,460,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,681,900.00	937,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	562,630.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,623,770.00	7,406,300.00
2106	Эд хопшил, урсгал засварын зардал	111,208,400.00	111,577,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	39,708,400.00	29,745,400.00
210602	Тавилга	3,500,000.00	-
210604	Урсгал засвар	68,000,000.00	81,832,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,700,000.00	1,110,000.00
210702	Дотоод албан томилолт	2,700,000.00	1,110,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	72,616,200.00	24,493,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	70,238,800.00	23,493,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,377,400.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,530,900.00	27,473,830.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,530,900.00	27,473,830.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	139,455,817.60	29,940,942.78
2132	Бусад урсгал шилжүүлэг	88,921,510.00	7,400,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,319,600.00	7,400,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	78,601,910.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	50,534,307.60	22,540,942.78
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,534,307.60	22,540,942.78
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>(18,090,528.51)</b>	<b>-</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(18,090,528.51)</b>	<b>-</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18,090,528.51	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	499,974,394.39	3,557,736.43	(5,484,979.05)	498,047,151.77
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	499,974,394.39	3,557,736.43	(5,484,979.05)	498,047,151.77
C07	Тайлант үеийн үр дүн	316,125,000.00	-	9,774,629,400.33	10,090,754,400.33
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	816,099,394.39	2,819,280.81	8,874,999,798.15	9,693,918,473.35
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	816,099,394.39	2,819,280.81	8,874,999,798.15	9,693,918,473.35
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,806,864.75	1,806,864.75
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	816,099,394.39	2,819,280.81	8,876,806,662.90	9,695,725,338.10
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(135,732,759.32)	(135,732,759.32)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	816,099,394.39	1,012,416.06	8,741,073,903.58	9,558,185,714.03

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
0	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,960,325,400.00</b>	<b>1,951,605,831.70</b>	8,719,568.30	99.56
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,935,607,400.00	1,915,687,831.70	19,919,568.30	98.97
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	24,718,000.00	35,918,000.00	(11,200,000.00)	145.31
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24,718,000.00	35,918,000.00	(11,200,000.00)	145.31
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	65	65	-	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	54	54	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	10	10	-	100.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,960,325,400.00</b>	<b>1,951,605,831.70</b>	8,719,568.30	99.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,960,325,400.00	1,951,605,831.70	8,719,568.30	99.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,952,878,400.00	1,921,664,888.93	31,213,511.07	98.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,652,495,800.00	1,626,738,708.60	25,757,091.40	98.44
210101	Үндсэн цалин	961,073,500.00	981,026,205.02	(19,952,705.02)	102.08
210102	Нэмэгдэл	532,288,900.00	466,650,075.07	65,638,824.93	87.67
210103	Унаа хоолны хөнгөлөлт	56,271,500.00	66,343,435.55	(10,071,935.55)	117.90
210104	Урамшуулал	102,861,900.00	112,718,992.96	(9,857,092.96)	109.58
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	205,812,000.00	205,753,450.33	58,549.67	99.97
210201	Тэтгэврийн даатгал	140,216,900.00	140,158,350.33	58,549.67	99.96
210202	Тэтгэмжийн даатгал	16,398,800.00	16,398,800.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,199,400.00	8,199,400.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	8,199,400.00	8,199,400.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	32,797,500.00	32,797,500.00	-	100.00
2104	Хангамж бараа материалын зардал	14,518,000.00	14,518,000.00	-	100.00
210401	Бичиг хэрэг	4,400,000.00	4,714,200.00	(314,200.00)	107.14
210402	Тээвэр, шатахуун	2,300,000.00	1,460,000.00	840,000.00	63.48
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,250,000.00	937,500.00	312,500.00	75.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,568,000.00	7,406,300.00	(838,300.00)	112.76
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,858,600.00	21,577,900.00	(1,719,300.00)	108.66
210601	Багаж техник, хэрэгсэл	19,858,600.00	21,577,900.00	(1,719,300.00)	108.66
2107	Томиллолт, зочны зардал	1,500,000.00	1,110,000.00	390,000.00	74.00
210702	Дотоод албан томиллолт	1,500,000.00	1,110,000.00	390,000.00	74.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,500,000.00	24,493,000.00	13,007,000.00	65.31
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,500,000.00	23,493,000.00	13,007,000.00	64.36
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,194,000.00	27,473,830.00	(6,279,830.00)	129.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,194,000.00	27,473,830.00	(6,279,830.00)	129.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,447,000.00	29,940,942.77	(22,493,942.77)	402.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,447,000.00	29,940,942.77	(22,493,942.77)	402.05
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал	7,447,000.00	7,400,000.00	47,000.00	99.37

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Аудитаар нийт 24,516.0 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа.Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланд тохируулга хийж тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан тоног төхөөрөмж болох 4,800.0 мянган төгрөгийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан гэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, ангилал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3. Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал 19,716.0 мянган төгрөгийг тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Залруулагдаагүй нийт 82,200.8 мянган төгрөгийн зөрчлөөс 23,240.0 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс 7,081.4 мянган төгрөгөөр бага тул “**Өөрчлөлтгүй**” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 82,200.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 6,740.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 24,667.5 таслан зогсоох 3 албан шаардлага өгч, 50,793.3 мянган төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлээ.

#### 5.1 Төлбөрийн акт

1. Тус байгууллагын грашд түрээсийн гэрээгүй 6 тээврийн хэрэгсэл үнэ төлбөргүйгээр ашиглуулсан зөрчил илэрлээ. Хүйтний 5 сарын хугацаанд 1 хоногийн 5.0 мянган төгрөгөөр бодож нэг тээврийн хэрэгслийн 750.0 мянган төгрөг, нийт 4,500.0 мянган төгрөгийг төсөвт төлүүлэх төлбөрийн акт тогтоов. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.2-т “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлсэн, ашиглуулсны төлбөр болон борлуулсны орлогыг дутуу төвлөрүүлсэн, эсхүл төвлөрүүлээгүй” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант онд “Би хаан болохгүй” жүжгийн тасалбарыг Хүмүүн 2-р сургуулиас 2,030.0 мянган төгрөг, Стандарт хэмжил зүйн газраас 210.0 мянган төгрөг нийт 2,240.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.2-т “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлсэн, ашиглуулсны төлбөр болон борлуулсны орлогыг дутуу төвлөрүүлсэн, эсхүл төвлөрүүлээгүй” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

## **5.2 Албан шаардлага**

1. Тус байгууллагын орлогыг нярав Б.Ариунхишигийн 5313988646 болон 5721156408 тоот Хаан банкны хувийн дансаар, бэлэн мөнгөөр авдаг зөрчил илэрлээ. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-т “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна”, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 1.5-д “Энэхүү журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө”, 2.1-д “Дотоод хяналт шалгалт нь хууль дээдлэх, хараат бус, ил тод, шударга, бодитой, хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид байх зарчимд тулгуурлана.”, 2.3-д “Дотоод хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг бүрэн хамарсан байвал зохино” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-т “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн албан шаардлага өгөв.

2. Тус байгууллага нь багаж, техник хэрэгслийн зардлаас зарцуулах эрх нээж өгөөгүй мөн өглөгөөр тусгаагүй байхад 2023 оны Аймгийн 100 жилийн ойгоор авсан тоног төхөөрөмжийн үлдэгдэл 8,167.5 мянган төгрөгийг “Смарт теч инженеринг” ХХК-д шилжүүлсэн байна. Аймгийн ЗДТГ-т нэхэмжилсэн төлбөрийг төлсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т “Хуулиар зөвшөөрөөгүй бусад”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-т “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн албан шаардлага өгөв.

3. Тайлант онд "Би хаан болохгүй" жүжгийг Хүмүүн 1, 2, 3, 4 дүгээр сургуулийн нийт 3300 хүүхдэд үзүүлэн, 1 тасалбарын үнийг 5.0 мянган төгрөгөөр тооцож нийт 16,500.0 мянган төгрөгийг тус байгууллагын нярвын дансанд болон бэлнээр өгсөн байна. Тус орлогыг харилцах дансандаа төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т “Хуулиар зөвшөөрөөгүй бусад”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-т “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн албан шаардлага өгөв.

### **5.3 Зөвлөмж**

1. Шилэн данстай холбоотой асуудал

#### **Илрүүлэлт:**

Тайлант оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт мэдээлбэл зохих 183 мэдээллийг мэдээлэхээс 7 мэдээлэл хугацаа хоцроосон ба өмч хөрөнгө, мөнгө зарцуулах аливаа шийдвэр, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг мэдээлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Шилэн дансны зарчим”-ыг гэсэн болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Өгсөн зөвлөмж:**

Цаашид Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь иж бүрэн оруулах.

2. Өр төлбөр данстай холбоотой асуудал

#### **Илрүүлэлт:**

Тус байгууллага нь тайлант онд Үйлдвэрчний эвэлэлийн өглөг 645.1 мянган төгрөг, түлш халаалтын өглөг 34,814.8 мянган төгрөг, байгууллагад төлөх өглөг 5,811.9 мянган төгрөг нийт 41,271.9 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг болон санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Өгсөн зөвлөмж:**

Цаашид төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

### 3. Авлага данстай холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

Тус байгууллага нь тайлант онд ажилчидтай холбогдсон 7,499.9 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг болон санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Цаашид төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

#### Илрүүлэлт:

4. Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг татварын Е баримт, Е посын дүнтэй тулгалт хийхэд Е баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс 2,021.5 мянган төгрөгөөр илүү байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар”-ын 6.5-д Төлбөрийн баримт “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ”, санхүүгийн тайлангийн аудитын “Иж бүрэн байх”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Цаашид худалдан авалт бүрийг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулах, худалдан авах гэрээнд цахим төлбөрийн баримт авах талаар тусгах, тухай бүр хяналт тавьж байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 25-ны дотор, биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган  
төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус байгууллага нь тайлант онд ҮЭ-ийн өглөг 645.1 мянган төгрөг, түлш халаалтын өглөг 34,814.8 мянган төгрөг, байгууллагад төлөх өглөг 5,811.9 мянган төгрөг нийт 41,271.9 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байна.	1	7,499.9					1	7,499.9
Тус байгууллага нь тайлант онд ажилчидтай холбогдсон 7,499.9 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.	1	7,499.9					1	7,499.9
Тайлант оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт мэдээлбэл зохих 183 мэдээллийг мэдээлэхээс 7 мэдээлэл хугацаа хоцроосон ба өмч хөрөнгө, мөнгө зарцуулах аливаа шийдвэр, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг мэдээлээгүй байна.		-					1	0
Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг татварын Е баримт, Е посын дүнтэй тулгалт хийхэд Е баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс 2,021.5 мянган төгрөгөөр илүү байна.	1	2,021.5					1	2,021.5
Тус байгууллага нь багаж, техник хэрэгслийн зардлаас зарцуулах эрх нээж өгөөгүй, мөн өглөгөөр тусгаагүй байхад 2023 оны Аймгийн 100 жилийн ойгоор авсан тоног төхөөрөмжийн үлдэгдэл 8,167.5 мянган төгрөгийг "Смарт төч инженеринг" ХХК-д шилжүүлсэн байна. Аймгийн ЗДТГ-т нэхэмжилсэн төлбөрийг төлсөн байна.	1	8,167.5			1	8,167.5		
Тус байгууллагын орлогыг нярав Б.Ариунхишигийн 5313988646 болон 5721156408 тоот Хаан банкны хувийн дансанд болон бэлэн мөнгөөр авдаг зөрчил илэрлээ.	1	-			1	-		
Тайлант онд "Би хаан болохгүй" жүжгийг Хүмүүн 1, 2, 3, 4 дүгээр сургуулийн нийт 3300 хүүхдэд үзүүлэн, 1 тасалбарын үнийг 5.0 мянган төгрөгөөр тооцож нийт 16,500.0 мянган төгрөгийг тус байгууллагын нярвын дансанд болон бэлнээр өгсөн байна. Тус орлогыг харилцах дансандаа төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ.	1	16,500.0			1	16,500.0		
"Би хаан болохгүй" жүжгийг Хүмүүн 2-р сургуулиас 2,030.0 мянган төгрөг, Стандарт хэмжил зүйн газраас 210.0 мянган төгрөг нийт 2,240.0 мянган	1	2,240.0	1	2,240.0				

төгрөгийн орлогыг төвлөрүүлээгүй байна.								
Тус байгууллагын грашд түрээсийн гэрээгүй 6 тээврийн хэрэгслийг үнэ төлбөргүй тавьдаг зөрчил илэрлээ. Хүйтний 5 сарын хугацаанд 1 хоногийн 5.0 мянган төгрөгөөр бодож нэг тээврийн хэрэгслийн 750.0 мянган төгрөг, нийт 4,500.0 мянган төгрөгийг төсөвт төлүүлэх төлбөрийн акт тогтоов.	1	4,500.0	1	4,500.0				
Дүн	9	82,200.8	2	6,740.0	3	16,667.5	4	50,793.3

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)